



ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ДАРГА
Д.БААСАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 3/462
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Цэвэр агаарын сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Цэвэр агаарын сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Цэвэр агаарын сан нь 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд ирүүлээгүй, 2013 оны санхүүгийн тайлангийн шалгах балансыг тулгахад 2,3 тэрбум, төсвийн гүйцэтгэлийн тайлан 1,2 тэрбум төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд бид дүгнэлт өгөх боломжгүйд хүргэж байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

071051

Дүгнэлт өгөхөөс татгалзах

Дээр дурдсан зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг тооцон Цэвэр агаарын сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэнг тогтоох боломжгүй байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХЗАЯА